



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 05 сарын 27 өдөр

Дугаар А/117

Бат-Өлзий сум

Гэрээ байгуулах тухай


Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэг, 44 дүгээр зүйлийн 44.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Могойт, Мойлтын зам засах ажлыг “Их сумт хайрхан” хязгаарлагдмал хариуцлагатай компанитай шууд худалдан авах аргаар гэрээ байгуулсугай.

2.“Их сумт хайрхан” хязгаарлагдмал хариуцлагатай компанитай гэрээ байгуулж, зам засварын ажилд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Бат-Эрдэнэ)-д даалгасугай.

3. Могойт, Мойлтын зам засах ажилд шаардагдах 9,900,000 (есөн сая есөн зуун мянга) төгрөгийг гэрээнд заасны дагуу Орон нутгийн хөгжлийн сангаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Б.Пүрэвсүрэн)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН